

“ТӨМӨР ЗАМЫН ДОХИОЛОЛ, ХОЛБООНЫ ЖУРАМ”

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Төмөр замын тээврийн тасралтгүй хэвийн, аюулгүй ажиллагаа, галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалтыг шуурхай удирдлагаар хангах, галт тэрэгний хөдөлгөөний болон сэлгээний хөдөлгөөний үеийн үзэгдэх болон дуут дохионы тогтолцоо, эдгээр дохиог өгдөг хэрэгслийн хэв маягийг тодорхойлж, тэдгээрийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Төмөр замын дохиоллын байгууламж, техник тоног төхөөрөмж, тэдгээрийн үйлчилгээнд тавигдах шаардлага болон дохиоллын зарчим нь “Төмөр замын техник ашиглалтын дүрэм”-д зааснаар зохицуулагдана.
- 1.3. Энэхүү журмаар тогтоосон дохио, тэмдгийн шаардлагыг чанд биелүүлснээр галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй, тасралтгүй ажиллагаа хангагдана.
- 1.4. Энэхүү журмаар тодорхойлсон дохио, тэмдгийн заалтыг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч бүр заавал дагаж мөрдөнө.
- 1.5. Энэхүү журмаар зохицуулагдаагүй дохиолол, холбооны систем ашигладаг бол суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж заавар баталж мөрдөж ажиллана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ДОХИОНЫ АНГИЛАЛ, ЗОРИУЛАЛТ

- 2.1. Дохио нь хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнийг зохион байгуулахад зориулагдана. Дохиог үзэгдэх, дуут гэж ангилна.
- 2.2. Үзэгдэх дохио нь дохионы заалтын өнгө, хэлбэр, байдал, тоогоор тодорхойлогдоно. Үзэгдэх дохионы хэрэгсэлд гэрлэн дохио, зээрэнхий, самбар, гар дохионы гэрэл, дарцаг, дохионы заагч ба тэмдэг орно.
 - 2.2.1. Үзэгдэх дохиог хэрэглэх байдлаар нь гурав ангилна.
 - 2.2.1.1. өдрийн дохиог хоногийн гэрэлтэй үед хэрэглэнэ. Үүнд: зээрэнхий, самбар, дарцаг, замын хаалт, сумын заагч орно.
 - 2.2.1.2. шөнийн дохиог хоногийн харанхуй үед хэрэглэнэ. Үүнд: гэрлэн дохионы тогтсон өнгийн гэрэл, зээрэнхий, гар чийдэн ба ишинд байрлуулсан га чийдэн, дохионы заагч орно.
 - 2.2.1.3. хоногийн туршид хэрэглэгдэх дохиог хоногийн гэрэлтэй ба харанхуй аль ч үед хэрэглэнэ. Үүнд: Гэрлэн дохионы тогтсон өнгийн

гэрэл, замнал заагч, хурд бууруулах байнгын зээрэнхий, галт тэрэгний сүүлийн улаан дохио, дохионы тэмдгүүд орно.

2.2.2. Манан будан, шороон болон цасан шуурга зэрэг байгаль цаг уурын үзэгдлээс шалтгаалан өдрийн цагт зогсоох дохио 1000 метрт, хурд бууруулах дохио 400 метрт үзэгдэхгүй байвал шөнийн дохиог хэрэглэнэ.

2.2.3. Төмөр замын хонгилд шөнийн болон хоногийн туршид хэрэглэгдэх дохиог байрлуулна.

2.3. Дуут дохио нь урт, богино дууны тоо, хослолоор тодорхойлогдоно. Эдгээрийн шаардлага нь өдөр, шөнийн цагт нэгэн адил байна.

2.3.1. Дуут дохио өгөхөд бүрээ, гар шүгэл, зүтгүүр ба өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний дуут дохио, тусгай зориулалтын дуут дохио, галт тэрэгний шүгэл, бялт зэргийг хэрэглэнэ.

2.3.2. Бялтны тэсрэлт галт тэргийг нэн даруй зогсоохыг шаардана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГЭРЛЭН ДОХИО

3.1. Гэрлэн дохио нь байнгын дохио бөгөөд дараах зориулалттай байна:

3.1.1. **Оруулах** – Өртөөг хоорондын замаас зааглах, галт тэргийг өртөө рүү орохыг зөвшөөрөх буюу хориглох;

3.1.2. **Гаргах** – Өртөөнөөс галт тэрэг хоорондын замд явуулахыг зөвшөөрөх буюу хориглох;

3.1.3. **Замналын** – Өртөөний парк хооронд галт тэрэг орохыг зөвшөөрөх буюу хориглох;

3.1.4. **Өнгөрүүлэх** – Нэг хориг-хэсгээс нөгөө хориг-хэсэгт орохыг зөвшөөрөх буюу хориглох;

3.1.5. **Халхлах** – Төмөр замын шугам нь бусад төмөр зам, троллейбус, трамвайны шугамтай нэг түвшинд огтлолцох хэсгийг өнгөрүүлэхийг зөвшөөрөх буюу хориглох;

3.1.6. **Хаах** – Гарам, том хэмжээний хиймэл төхөөрөмж болон уулын хэсэгт нуралт үүсэж болзошгүй газарт хөдөлгөөнд аюултай саад гарахад галт тэргийг зогсоох;

3.1.7. **Анхааруулах** – Оруулах, өнгөрүүлэх, хаах, халхлах гэрлэн дохионы заалтыг урьдчилан анхааруулах;

3.1.8. **Сэлгээний** – Сэлгээний хөдөлгөөн хийхийг зөвшөөрөх буюу хориглох;

3.1.9. **Довын** – Довоос вагоныг ялган тараахыг зөвшөөрөх буюу хориглох;


3.1.10. **Давтах** – Гаргах, замналын, довын үндсэн гэрлэн дохионы заалт тухайн газрын байдлаас үзэгдэлт хангалтгүй байвал түүний заалтыг давтах;

3.1.11. **Нэвтрэх** – Төмөр замтай бүхий барилга байгууламж, үйлдвэрлэлийн бүс, талбайд нэвтрэхийг зөвшөөрөх буюу хориглох.


3.2. Гэрлэн дохио нь ламптай ба гэрэлт диодтой байна.

3.3. Гэрлэн дохиог шонтой /*Зураг 1*/, шонгүй /*Зураг 2*/ ба хөндлөвч, консоль дээр байрлуулсан гэж ангилна.

3.4. Нэг гэрлэн дохио /гаргах ба сэлгээний, гаргах ба замналын гэх мэт/ хэд хэдэн зориулалттай байж болно.



Зураг 1



Зураг 2

3.5. Гэрлэн дохионы ялгах тэмдгийг үсэг буюу үсэг тоогоор илэрхийлж бүх гэрлэн дохионы шон болон суурьт байрлуулна.

3.6. Байрлал ба зориулалтаас үл хамааран гэрлэн дохиогоор дараах үндсэн дохиог өгнө. Үүнд:

3.6.1. **Нэг ногоон гэрэл** – Галт тэрэг тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио нээлттэй.

3.6.2. **Анивчсан нэг шар гэрэл** – Галт тэрэг тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио нээлттэй, гэрлэн дохиог бууруулсан хурдтай өнгөрөхийг шаардана.

3.6.3. **Нэг шар гэрэл** – Галт тэрэг зогсоход бэлэн явна, дараагийн гэрлэн дохио хаалттай.


3.6.4. **Дээд тал нь анивчсан хоёр шар гэрэл** – Галт тэрэг хажуугийн замаар орно, гэрлэн дохиог бууруулсан хурдтай өнгөрөхийг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио нээлттэй.

3.6.5. **Хоёр шар гэрэл** – Галт тэрэг хажуугийн замаар орно, дараагийн гэрлэн дохионы өмнө зогсоход бэлэн, бууруулсан хурдтай өнгөрөхийг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио хаалттай

3.6.6. **Нэг улаан гэрэл** – Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно.


3.6.7. Оруулах гэрлэн дохио дараах дохиог өгнө:

3.6.8. **Нэг ногоон гэрэл** – Галт тэрэг өртөөний гол замаар тогтоосон хурдтай орохыг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио /замналын, гаргах/ нээлттэй. /Зураг 3/




Зураг 3

3.6.9. **Анивчсан нэг шар гэрэл** – Галт тэрэг өртөөний гол замаар тогтоосон хурдтай орохыг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио /замналын, гаргах/ нээлттэй, гэрлэн дохионы дэргэдүүр бууруулсан хурдтай өнгөрөхийг шаардана. /Зураг 4/




Зураг 4


3.6.10. **Нэг шар гэрэл** – Галт тэрэг гол замаар зогсоход бэлэн явж өртөөнд орохыг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио хаалттай. /Зураг 5/




3.6.11. **Хоёр шар гэрэл** – Галт тэрэг хажуугийн замаар зогсоход бэлэн бууруулсан хурдтай өртөөнд орохыг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио хаалттай. /Зураг 6/



Дээд тал нь анивчсан хоёр шар гэрэл – Галт тэрэг хажуугийн замаар орно, гэрлэн дохионы дэргэдүүр бууруулсан хурдтай өнгөрөхийг зөвшөөрнө, дараагийн гэрлэн дохио нээлттэй. /Зураг 7/




3.6.12. **Нэг улаан гэрэл** – Зогс! дохио өнгөрөхийг хориглоно. /Зураг 8/




Зураг 8

3.7. Урих гэрлэн дохиог оруулах, замналын, гаргах гэрлэн дохионд (бүлэглэснээс бусад) байрлуулна. Урих гэрлэн дохио нь дараах дохиог өгнө.

3.7.1. **Анивчсан нэг цагаан гэрэл** – Оруулах, замналын /автомат хориглолоор тоноглогдсон хэсэгт хос замын хөдөлгөөн зохицуулалттай бол дагуу чиглэлд гаргах/ гэрлэн дохио нээгдэхгүй улаан гэрэлтэй, эсвэл унтарсан үед галт тэрэг дараагийн гэрлэн дохио /гаргах дохиогүй бол хүлээн авах замын хязгаарын шон/ хүртэл 20 км/цагаас ихгүй хурдтай, саад тохиолдвол зогсоход бэлэн онцгой сэрэмжтэй хөдөлгөөнийг үргэлжлүүлэхийг зөвшөөрнө. /Зураг 9, 10/.



Зураг 9



Зураг 10

3.8. Гаргах гэрлэн дохио дараах дохиог өгнө:

3.8.1. **Нэг ногоон гэрэл** – Галт тэрэг тогтоосон хурдтай ертөөнөөс явахыг зөвшөөрнө. Дараагийн ертөө /замын пост/ хүртэл хоорондын зам чөлөөтэй. /Зураг 11/



Зураг 11

3.8.2. **Хоёр шар гэрэл** – Галт тэрэг өртөөнөөс хажуугийн замаар бууруулсан хурдтай явахыг зөвшөөрнө. Дараагийн өртөө хүртэл хоорондын зам чөлөөтэй. /Зураг 12/



Зураг 12

3.8.3. **Нэг улаан гэрэл** – Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно. / Зураг 13/



Зураг 13

3.8.4. **Хоёр ногоон гэрэл** – Галт тэрэг өртөөнөөс салаалсан хоорондын замд явахыг зөвшөөрнө. Дараагийн өртөө хүртэл хоорондын зам чөлөөтэй. /Зураг 14/




Зураг 14

3.9. Автомат хориглолтой хэсэгт гаргах гэрлэн дохио дараах дохиог өгнө:


3.9.1. **Нэг ногоон гэрэл** – Галт тэргийг өртөөнөөс тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө. Дараагийн хоёр болон түүнээс дээш хориг-хэсэг чөлөөтэй. /Зураг 11/

3.9.2. **Нэг шар гэрэл** – Галт тэрэг зогсоход бэлэн хурдтайгаар өртөөнөөс явахыг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио хаалттай. /Зураг 15/



Зураг 15

3.9.3. **Дээд тал нь анивчсан хоёр шар гэрэл** – Галт тэрэг бууруулсан хурдтай өртөөний хажуугийн замаас явахыг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио нээлттэй. /Зураг 16/




Зураг 16

3.9.4. **Хоёр шар гэрэл** – Галт тэрэг бууруулсан хурдтай өртөөний хажуугийн замаас явахыг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио хаалттай. /Зураг 12/

3.9.5. **Нэг улаан гэрэл** – Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно. Дараагийн хориг-хэсэг эзэлгээтэй.


3.10. Халхлах гэрлэн дохио дараах дохиог өгнө:

3.10.1. **Нэг ногоон гэрэл** – Галт тэрэг тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө. /Зураг 17/



Зураг 17


3.10.2. Нэг улаан гэрэл – Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно./Зураг 18/



Зураг 188


3.11. Хаах гэрлэн дохио дараах дохиог өгнө:

3.11.1. Нэг улаан гэрэл – Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно./Зураг 19/




Зураг 19

3.11.2. Хаах гэрлэн дохионы өмнөх анхааруулах гэрлэн дохионы **Нэг шар гэрэл** – Үндсэн хаах гэрлэн дохио хаалттай, зогсоход бэлэн хурдтайгаар явахыг зөвшөөрнө. /Зураг 20/



Зураг 20


3.11.3. Гармын хаах дохио нь хэвийн байдалдаа улаан гэрэлтэй байна. Гарамд галт тэрэг ойртон ирэхэд гармын авто хөсөгт зориулсан хориглолын байгууламж бүрэн ажилласан (гэрлэн дохио ассан, хөндлөвч хаалт буусан, сөхөгддөг хаалт сөхөгдсөн) үед харанхуй болно. Хаах гэрлэн дохио, түүний анхааруулах гэрлэн дохио асахгүй /харанхуй/ байх нь дохионы үүрэг гүйцэтгэхгүй. Хаах гэрлэн дохио улаан гэрэлтэй үед галт тэрэгний машинч гарам дээр саад байхгүйг магадлан бол 20 км/цагаас ихгүй хурдтай, саад тохиолдвол яаралтай зогсоход бэлэн онцгой сэрэмжтэй хөдөлгөөнийг үргэлжлүүлэхийг зөвшөөрнө. Дохионы шонг хар, цагаан өнгөөр алаглуулан будсан байна. /Зураг 21/



Зураг 21


3.12. Оруулах, өнгөрүүлэх, халхлах гэрлэн дохионы өмнө тавигдсан анхааруулах гэрлэн дохио дараах дохиог өгнө:

3.12.1. **Нэг ногоон гэрэл** – Галт тэрэг тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө. Үндсэн гэрлэн дохио нээлттэй. /Зураг 22/



Зураг 22

3.12.2. **Нэг шар гэрэл** – Галт тэрэг зогсоход бэлэн явахыг зөвшөөрнө. Үндсэн гэрлэн дохио хаалттай. /Зураг 23/




Зураг 23

3.12.3. **Анивчсан нэг шар гэрэл** – Галт тэрэг тогтоосон хурдтай өнгөрөхийг зөвшөөрнө. Оруулах гэрлэн дохио нээлттэй. Оруулах гэрлэн дохионы дэргэдүүр бууруулсан хурдтай өнгөрөхийг шаардана.

3.13. Давтах гэрлэн дохио дараах дохиог өгнө:

3.13.1 **Нэг ногоон гэрэл** – Гаргах, замналын, довын гэрлэн дохио нээлттэй. /Зураг 24/

3.13.2. Давтах гэрлэн дохионы гэрэл хэвийн байдалдаа асахгүй /харанхуй/ ба энэ байдалд дохионы үүрэг гүйцэтгэхгүй.



Зураг 24

3.14. Замналын гэрлэн дохио дараах дохиог өгнө:

3.14.1. **Нэг ногоон гэрэл** – Галт тэрэг тогтоосон хурдтай гэрлэн дохио өнгөрөхийг зөвшөөрнө. Дараагийн замналын ба гаргах гэрлэн дохио нээлттэй.

3.14.2. **Нэг шар гэрэл** – Галт тэрэг зогсоход бэлэн гэрлэн дохионы дэргэдүүр өнгөрөхийг зөвшөөрнө. Дараагийн замналын ба гаргах гэрлэн дохио хаалттай.

3.14.3. **Анивчсан нэг шар гэрэл** – Галт тэрэг тогтоосон хурдтай гэрлэн дохио өнгөрөхийг зөвшөөрнө. Дараагийн замналын ба гаргах гэрлэн дохио нээлттэй, бууруулсан хурдтай өнгөрөхийг шаардана.

3.14.4. **Дээд тал нь анивчсан хоёр шар гэрэл** – Галт тэрэг бууруулсан хурдтай хажуугийн замаар өнгөрөхийг зөвшөөрнө. Дараагийн замналын, гаргах гэрлэн дохио нээлттэй.

3.14.5. **Хоёр шар гэрэл** – Галт тэрэг бууруулсан хурдтай гэрлэн дохио өнгөрөхийг зөвшөөрнө. Хажуугийн зам руу орно. Дараагийн гэрлэн дохио хаалттай. Зогсоход бэлэн яв!

3.14.6. **Нэг улаан гэрэл – Зогс!** Дохио өнгөрөхийг хориглоно.

3.15. Өнгөрүүлэх гэрлэн дохио автомат хориглолоор тоноглогдсон хоорондын замд дараах дохиог өгнө.

3.15.1. **Нэг ногоон гэрэл** – Галт тэрэг тогтоосон хурдтай явахыг зөвшөөрнө. Дараагийн хоёр болон түүнээс дээш хориг-хэсэг чөлөөтэй.

3.15.2. **Нэг шар гэрэл** – Галт тэрэг зогсоход бэлэн өнгөрөхийг зөвшөөрнө. Дараагийн гэрлэн дохио хаалттай.

3.15.3. **Нэг улаан гэрэл – Зогс!** Дохио өнгөрөхийг хориглоно.


3.16. Нэвтрэх гэрлэн дохио дараах дохиог өгнө.

3.16.1. **Нэг шар гэрэл** – Галт тэрэг зогсоход бэлэн өнгөрөхийг зөвшөөрнө. Барилга байгууламж, үйлдвэрлэлийн бүс, талбайд нэвтэрч болно. Зураг 25



Зураг 25


3.16.2. **Нэг улаан гэрэл** – **Зогс!** Барилга байгууламж, үйлдвэрлэлийн бүс, талбайд нэвтэрхийг хориглоно. /Зураг 26/



Зураг 26


3.17. Хурд бууруулах байнгын зээрэнхий нь дараах дохиог өгнө:

3.17.1. **Шар зээрэнхий** – “Осолтой газрын эхлэл”, “Осолтой газрын төгсгөл” дохионы тэмдгээр хязгаарлагдсан осолтой газрыг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн тогтоосон хурдтай өнгөрөхөд бэлтгэж, хурдаа бууруулж явахыг зөвшөөрнө. /Зураг 27/




Зураг 27

3.17.2. Ногоон зээрэнхий – Галт тэрэг осолтой газрыг өнгөрснийг заана. Энэ заалт нь хоорондын замд машинчид хөдөлгөөний чиглэлийн дагуу зүүн гар талд харагдана. Хурд бууруулах байнгын зээрэнхий нь шар өнгөтэй, ар тал нь ногоон өнгөтэй байх ба гэрэл ойлгогч материалаар хийгдсэн байна. /Зураг 28/




Зураг 28

3.18. Суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн тушаалд заасан хурд бууруулах осолтой газрыг түүний захаас хоёр тийш 50 метрийн зайд “Осолтой газрын эхлэл”*, “Осолтой газрын төгсгөл” гэсэн дохионы тэмдгээр хязгаарлана. /Зураг 29/



Зураг 29 †

3.19. Ажиллагаанд оруулаагүй (хамааралд оруулаагүй) гэрлэн дохиог унтрааж хэрээс тэмдгийг дохионы заалтуудын доор байрлуулна. /Зураг 30/



Зураг 30

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗӨӨВРИЙН ДОХИО


4.1. Зөөврийн дохионд ар, өвөр тал нь гэрэл ойлгогч бүхий улаан өнгийн тэгш өнцөгт дөрвөлжин самбар, нэг тал нь шар, нөгөө тал нь ногоон өнгийн тэгш өнцөгт дөрвөлжин самбар, урт ишинд байрлуулсан улаан гэрэл, улаан, шар дарцаг хамаарагдана.

* – Энэ тэмдгээс хүснэгт 1-д үзүүлсэн баримтлах хэвгий, хөдөлгөөний хурднаас хамаарсан “А” зайд хурд бууруулах байнгын зээрэнхийг байрлуулна.


† – Зураг, хүснэгтэд заагдсан тоо нь зай хэмжээг метрээр илэрхийлсэн болно.

4.2. “Зөөврийн дохио” ‡ – оор дараах шаардлагыг тавина:

4.2.1. Өдөр улаан өнгөтэй тэгш өнцөгт дөрвөлжин самбар буюу улаан дарцаг/Зураг 31/, шөнө урт ишинд байрлуулсан улаан гэрлээр /Зураг 32/ «Зогс! Дохио өнгөрөхийг хориглоно» гэсэн дохиог өгнө.




Зураг 31



Зураг 32

4.2.2. Шар өнгийн дөрвөлжин самбараар “Зогсоох буюу хурд бууруулж өнгөрөх шаардлагатай, осолтой газар дөхөж байна. Бууруулсан хурдтай яв!” гэсэн дохиог өгнө. /Зураг 33/




Зураг 33

4.2.3. Өртөөний зам дээр байрлуулсан шар өнгөтэй дөрвөлжин самбар бүхий зөөврийн дохионы дэргэдүүр 25 км/цагаас ихгүй хурдтай өнгөрнө.

4.2.4. Урт ишинд байрлуулсан ногоон өнгийн дөрвөлжин самбар нь галт тэрэг осолтой газраар өнгөрсөн болохыг заана. /Зураг 34/

‡ – зөөврийн дохионы ишийг дохионы үндсэн болон цагаан өнгөөр алаглуулан будна.




Зураг 34

4.3. Галт тэрэг ирэх хэсгийг үл харгалзан хоорондын замын хөдөлгөөнд саад гарсан газрыг зогсоох дохиогоор хааж хамгаална. Галт тэрэгний хөдөлгөөнд саадтай газар болон хоорондын замд ажил хийх газрыг дараах байдлаар хамгаална.



4.3.1. Галт тэрэг ирэх эсэхийг үл харгалзан хоорондын замд хөдөлгөөнд саад гарсан газрыг зогсоох дохиогоор “Зураг 35”, “Зураг 36”, “Зураг 37”-д заасан бүдүүвчийн дагуу хааж хамгаална.

4.3.2. Бялтыг эхний /“Б” зайд[§] байрлах/ бялтаас саадтай газар тийш 20 метр зайд улаан дохио барьсан төмөр замын ажилтан хамгаална.



Зураг 35

[§] **ТАЙЛБАР:** 1 дүгээр хүснэгтийн “Б”-д саадтай ба ажил хийх газарт хориг хамгаалалт тавих зайг хоорондын замын баримтлах хэвгий ба галт тэрэгний хурдтай уялдуулан заасан болно.




4.3.3. Хоорондын замд хийгдэх ажил нь галт тэргийг зогсоохоор байвал уг газрыг саадтай газрын нэгэн адил хамгаална.

4.3.4. хурд бууруулах зөөврийн дохио, бялтыг эхний бялтаас ажил хийж байгаа газар тийш 20 метр зайд улаан дохио барьсан дохиочин хамгаална.


4.3.5. зөөврийн улаан дохио ажил удирдагчийн хяналтад байна.

4.3.6. саадтай газрын дэлгэмэл талбай 200 метрээс их байгаа тохиолдолд саадтай газрыг хаасан улаан самбарыг дохиочин хамгаална. /Зураг 38/



4.3.7. Хаалт шаардагдах хэсгийн заагаас 50 метрийн зайд тавигдсан зөөврийн улаан дохиог улаан дохио барьсан дохиочин хамгаална.

4.3.8. Хоорондын замд ажил хийж байгаа буюу саадтай газар нь өртөөнд ойр бөгөөд энэ газрыг тогтоосон бүдүүвчийн дагуу хамгаалах боломжгүй бол түүнийг хоорондын замын талаас тогтоосон бүдүүвчийн дагуу хамгаалах ба өртөөний талаас оруулах гэрлэн дохио эсвэл өртөөний зааг /Зураг 85/ тэмдгийн харалдаа замын тэнхлэг дээр зөөврийн улаан дохио, гурван бялт тавьж дохиочноор хамгаалуулна. /Зураг 39/




4.3.9. Хэрэв саадтай газар оруулах гэрлэн дохионоос 50 метр-с бага зайд байвал өртөө талд бялт тавихгүй.

4.3.10. Дохиочин нь төмөр замын тээврийн бусад ажилтнаас ялгагдах шар өнгийн малгайтай байна.

4.3.11. Галт тэрэг зөөврийн шар дохионд ойртох үед машинч зүтгүүрийн шүглээр нэг урт дохио өгөх бөгөөд хурд бууруулан улаан дохио барьсан дохиочинд ойртохдоо зогсох дохио өгч, улаан дохио өнгөрөхгүй зогсоно.

4.3.12. Гэнэт саад гарах тохиолдолд зогсоох зөөврийн дохио газар дээрээ байхгүй бол саадтай газарт зогсоох дохио /өдөр улаан дарцаг, шөнө улаан

гэрэл/-г нэн даруй тавих ба саадтай газраас хоёр тийш бүдүүвчийн дагуу “Б” зайд бялт тавина. /Зураг 40/



Хүснэгт 1 Хоорондын замд гарсан саад болон осолтой газарт хурд бууруулах дохио, бялт тавих зай.


д/д	Хоорондын замын баримтлах хэвгий ба галт тэрэгний хөдөлгөөний хурд	Осолтой газрын эхлэл тэмдгээс хурд бууруулах дохио хүртэл “А” зай /метр/	Зөөврийн улаан дохио ба гэнэт гарсан саадтай газраас нэгдүгээр бялт хүртэлх “Б” зай /метр/
1	0.006-аас бага баримтлах хэвгийтэй хоорондын замд ачааны галт тэрэгний хурд 80 км/цагаас ихгүй, зорчигчийн галт тэрэгний хурд 100 км/цагаас ихгүй байхад	800	1000
2	0.006-0.014 баримтлах хэвгийтэй хоорондын замд ачааны галт тэрэгний хурд 80 км/цагаас ихгүй, зорчигчийн галт тэрэгний хурд 100 км/цагаас ихгүй байхад	1000	1200
3	0.014-ээс дээш хэмжээний баримтлах хэвгийтэй хоорондын замд	1300	1600

4.3.13. Нэг замтай хэсэгт галт тэрэг аль талаас ирэх нь мэдэгдэхгүй байвал дохиог эхлээд уруудуур талд, тэгш зам дээр бол эхлээд тахир буюу сэтэрхий талд тус тус тавина.


4.4. Бялтыг ямар ч үед гурван ширхгийг тавина. Үүнд: хоёрыг галт тэрэгний хөдөлгөөний чиглэлийн дагуу баруун талын зам төмөр дээр, нэгийг зүүн талын зам төмөр дээр түрүүчийн хоёр бялтын дунд тавина. Бялт хоорондын зай 20 метр байна.

4.5. Хурд бууруулах зөөврийн дохиог байнгын дохионы бүдүүвчийн дагуу байрлуулна. /Зураг 29/

4.5.1. Машинч нь зөөврийн шар дохионд ойртон очихдоо зүтгүүрийн шүглээр нэг урт дохио өгөх бөгөөд «Осолтой газрын эхлэл» /Зураг 41/ ба «Осолтой газрын төгсгөл» /Зураг 42/ гэсэн дохионы тэмдгээр хязгаарлагдсан газрыг анхаарамжид заасан хурдтай, харин анхаарамж олгоогүй бол 25 км/цагаас ихгүй хурдтай өнгөрөхөөр галт тэргийг жолоодно.




Зураг 41




Зураг 42

4.5.2. Хурд бууруулах шаардлагатай газар нь өртөөнд ойрхон байснаас хурд бууруулах дохиогоор тогтоосон бүдүүвчийн дагуу хамгаалах боломжгүй бол шар самбарыг гаргах суман шилжүүлгийн шорын үзүүрийн харалдаа тавьж, осолтой газрын төгсгөлөөс 50 метр зайд «Осолтой газрын эхлэл» тэмдгийг тавина. /Зураг 43/



Зураг 43

4.6. Зогсоох буюу хурд бууруулах дохиогоор хаах шаардлагагүй боловч галт тэрэг ойртож буйг ажилтан нарт анхааруулах шаардлагатай ажил хийж байгаа газрыг мөн түүнчлэн зэрэгцээ гол замын тухайн хэсгийг замын хажууд байрлуулсан шүгэл дуугаргахыг шаардах “Ш” гэсэн тэмдэгтэй /Зураг 36, 39, 43, 44/ зөөврийн дохиогоор хамгаална.



Зураг 44

4.7. Өртөөн дээрх галт тэрэгний хөдөлгөөнд саадтай ба ажил хийж байгаа газрыг дараах байдлаар хамгаална:

4.7.1. Хөдлөх бүрэлдэхүүн байгаа эсэхээс үл харгалзан өртөөний зам болон суман шилжүүлгийн ажиллагаанд саад гарвал уг газрыг зогсоох дохиогоор хамгаална.


4.7.2. Өртөөний зам дээрх саадтай буюу ажил хийж байгаа газрыг зогсоох дохиогоор хамгаалахдаа хөдлөх бүрэлдэхүүнийг тухайн газар руу орох боломжгүй байдлаар хязгаарлах сумуудыг цоожлох, түгжих буюу хадна.

Саадтай буюу ажил хийж байгаа газрын замын голд зөөврийн улаан дохио байрлуулна. /Зураг 45/




Зураг 45

4.7.3. Суман шилжүүлгийн шор зайлшгүй шаардлагаар саадтай буюу ажил хийж байгаа газар руу чиглэсэн бөгөөд тусгаарлах бололцоогүй байвал тухайн газрын заагаас 50 метрийн зайд зөөврийн улаан дохио байрлуулна. /Зураг 46/




Зураг 46

4.7.4. Суман шилжүүлгийн шор нь саадтай буюу ажил хийж байгаа газарт 50 метрээс ойр байрласан байвал шорын хооронд зөөврийн улаан дохио байрлуулна. /Зураг 47/




Зураг 47


4.7.5. Суман шилжүүлэг дээрх саадтай буюу ажил хийж байгаа газрыг зөөврийн улаан дохиогоор хамгаалахдаа тонолжийн талаас нийлсэн зам тус бүрийн голд хязгаарын шонгийн харалдаа, нөгөө талаас сумын шороос 50 метрийн зайд уул дохиог тус тус байрлуулна. /Зураг 48/



4.7.6. Хамгаалбал зохих суман шилжүүлэг рүү хөдлөх бүрэлдэхүүн оруулахгүй байх боломжтой өөр суман шилжүүлэг байрласан бол тухайн суман шилжүүлгийг хамгаалах байдалд нь шилжүүлж цоожлох, түгжих буюу хадна. Энэ тохиолдолд хамгаалах суман шилжүүлгийн талд зөөврийн улаан дохио тавихгүй. /Зураг 49/



4.7.7. Саадтай буюу ажил хийж байгаа газар нь оруулах суман шилжүүлэг дээр байвал түүнийг хоорондын замын талаас хориглосон заалттай оруулах гэрлэн дохиогоор хаах, өртөөний талаас нийлсэн зам тус бүрд хязгаарын шонгийн харалдаа зөөврийн улаан дохио байрлуулж хаана. /Зураг 50/




4.7.8. Саадтай буюу ажил хийж байгаа газар нь оруулах суман шилжүүлэг, оруулах гэрлэн дохио хоёрын хооронд байвал уул газрыг хоорондын зам талаас хориглосон заалттай оруулах гэрлэн дохиогоор, өртөөний талаас оруулах суман шилжүүлгийн шорын хооронд байрлуулсан зөөврийн улаан дохиогоор тус тус хамгаална. /Зураг 51/



Зураг 51


4.7.9. Суман шилжүүлэг дээр саад тохиолдсоныг илрүүлсэн төмөр замын ажилтан саадтай газарт /засварын ажил эхэлтэл/ нэн даруй зөөврийн улаан дохио тавьж тэр тухайгаа өртөөний жижүүрт мэдэгдэнэ.

4.7.10. Өртөөний замд овор хангахгүй хөдлөх бүрэлдэхүүн зогссон үед зэргэлдээ замаас хөдлөх бүрэлдэхүүн орж болох бусад замуудыг зогсоох дохиогоор хамгаална. /Зураг 52/




Зураг 52

4.7.11. Өртөөний гол замаар өнгөрөх галт тэрэг болон хөдлөх бүрэлдэхүүний хурдыг анхаарамжид заасан хэмжээнд хүртэл бууруулах шаардлагатай газрыг хурд бууруулах зөөврийн дохиогоор “Зураг 53”-д үзүүлсэн бүдүүвчийн дагуу хамгаална.



4.7.12. Өртөөний бусад замд хурд бууруулах шаардлага гарвал зөөврийн шар дохиогоор хамгаална. /Зураг 54/




4.8. Өртөөний зам дээр аюултай ачаатай вагоныг хамгаалах зааврыг өртөөний техник захирамжийн актаар тогтооно.


4.9. Хоорондын замд аргагүйдэн зогссон үед галт тэргийг дараах байдлаар хамгаална.

4.9.1. галт тэргийг хамгаалахдаа машинч нь төмөр замын бусад ажилтныг хамгаалах ажилд татан оролцуулах эсхүл туслах машинчаар гүйцэтгүүлнэ.

4.9.2. Зорчигчийн галт тэрэг зогссон үед тусламж ирэх талд нь /галт тэрэгний толгой талаас туслах машинч /Зураг 56/, сүүл талаас сүүлийн вагоны үйлчлэгч /Зураг 55// 800 метрээс багагүй зайд бялт тавьж, тэрхүү бялт тавьсан газраас галт тэрэг талд 20 метр зайд дээр дурдсан ажилтан улаан дохио барьж хамгаална.



Зураг 55



Зураг 56

4.9.3. Сэргээн босгох буюу галын галт тэрэг, туслах зүтгүүр шаардсан үед тусламж аль талаас ирэх нь мэдэгдэхгүй тохиолдолд дээрх ажилтнуудаас галт тэрэгний хоёр талд метрээс багагүй зайд бялт тавьж, тэрхүү бялт тавьсан газраас галт тэрэг талд 20 метр зайд дээр дурдсан ажилтан улаан дохио барьж хамгаална. /Зураг 57/



Зураг 57

4.9.4. Сэргээн босгох буюу галын галт тэрэг, туслах зүтгүүрийг дуудаж хаалт, хамгаалалтын дохио тавьсан бол галт тэрэг буюу зүтгүүр дохионы

дэргэд ирж зогссоны дараа түүнийг хурааж авна. Цаашид ажил удирдагчийн заавраар сэлгээний зарчмаар галт тэрэгний бүрэлдэхүүнд очиж холбогдоно.

4.9.5. Галт тэрэг хоорондын замд зогссон ба түүнийг өртөөнд хэсэгчлэн зөөх үед хоорондын замд үлдсэн хэсгийн хоёр талд нь 800 метрээс багагүй зайд бялт тавьж хамгаална.

ТАВДУГААР БҮЛЭГ

ГАР ДОХИО

5.1. Гар дохионы хэрэгслээр дараах дохиог өгнө.

5.1.1. Өдөр дэлгэсэн улаан дарцаг /Зураг 57/, шөнө улаан гэрэл /Зураг 58/ – “Зогс!” хөдөлгөөнийг хориглоно.



Зураг 58



Зураг 59

5.1.2. өдрийн цагт улаан дарцаггүй, шөнийн цагт улаан гэрэлгүй тохиолдолд өдөр шар дарцаг /Зураг 59/, өөр ямар нэгэн зүйлээр, шөнө өөр өнгийн гэрлээр /Зураг 60/, гараараа бүтэн тойргоор эргүүлж зогсоох дохио өгнө.



Зураг 60



Зураг 61

5.1.3. өдөр дэлгэсэн шар дарцаг, шөнө шар гэрэл – анхаарамж бичигт буюу суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн тогтоосон хурдаар явах, харин анхаарамж бичиггүй бол 25 км/цагаас ихгүй хурдтай явахыг зөвшөөрнө. /Зураг 62/



Зураг 62

5.1.4. хурд бууруулах дохиог шөнө цагаан гэрлээр дээш, доош нь алгуур хөдөлгөж өгнө. /Зураг 63/




Зураг 63

5.2. Тоормосыг шалгах үед дараах дохиог өгнө.

5.2.1. машинчид анхааруулсны дараа тоормос туршихыг шаардахдаа өдөр гараар /Зураг 64/, шөнө цагаан гэрлээр /Зураг 65/ дээш нь өргөж дохио өгнө.



Зураг 64



Зураг 65

5.2.2. машинч зүтгүүрийн шүглийг нэг богино дуугаргаж хариу дохио өгөөд тоормосолж эхэлнэ.

5.2.3. тоормос суллахыг машинчаас шаардахдаа өдөр гараар /Зураг 66/, шөнө цагаан гэрлээр /Зураг 67/ өөрийнхөө урдуур гараа сунгаж хоёр тийш нь хөдөлгөж дохио өгнө.



Зураг 66



Зураг 67

5.2.4. машинч зүтгүүрийн шүглийг хоёр богино дуугаргаж хариу дохио өгөөд тоормосоо суллана.

5.3. Дохиочин, өртөөний жижүүр галт тэргийг дараах байдлаар угтаж авна:

5.3.1. галт тэргийг явуулах буюу өртөөгөөр зогсолтгүй өнгөрүүлэхдээ өдөр хуйлсан шар дарцаг /Зураг 68/, шөнө ногоон гэрлийг /Зураг 69/ дээш нь өргөн дохио өгнө. Энэ дохио нь галт тэрэг өртөөгөөр өнгөрөхдөө тогтоосон хурдаар явж болохыг илтгэнэ.



Зураг 68




Зураг 69

5.3.2. зогсолтгүй өнгөрөх галт тэргийг өртөөн дээр зогсоох тохиолдолд өдөр дэлгэсэн улаан дарцаг /Зураг 70/, шөнө улаан гэрлийг /Зураг 71/ дээш өргөн дохио өгнө.




Зураг 70




Зураг 71

5.4. Өртөөний жижүүрийн байрыг сумчны байранд нэгтгэсэн хэсэглэх газруудад сумчин, өртөөний жижүүр галт тэргийг дараах байдлаар угтаж, үднэ:

5.4.1. галт тэргийг явуулах, өртөөгөөр зогсолтгүй өнгөрүүлэхдээ өдрийн цагаар хуйлсан шар дарцаг /Зураг 72/, шөнийн цагаар цагаан гэрлийг /Зураг 73/ дээш нь өргөн дохио өгнө.




Зураг 72




Зураг 73

5.4.2. галт тэргийг хажуугийн замаар, өртөөн дээр зогсолттой хүлээж авахдаа оруулах сумчны байранд өдрийн цагаар дэлгэсэн шар дарцаг /Зураг 74/, шөнийн цагаар шар гэрлээр /Зураг 75/ дохио өгч угтана.



Зураг 74



Зураг 75

5.4.3. өртөөнөөс явж байгаа галт тэргийг сумчин өдрийн цагаар хуйлсан шар дарцаг, шөнийн цагаар цагаан гэрлээр дохио өгнө.

5.4.4. зогсолтгүй өнгөрөх галт тэргийг өртөөн дээр зогсоох тохиолдолд оруулах сумчны байранд өдрийн цагаар дэлгэсэн шар дарцаг, шөнийн цагаар шар гэрлээр дохио өгч угтах ба гаргах сумчны байранд өдрийн цагаар дэлгэсэн улаан дарцаг, шөнийн цагаар улаан гэрлийг дээш өргөн дохио өгнө.

5.5. Зогсоох дохиог галт тэрэгнээс өгөхдөө өдрийн цагаар дэлгэсэн улаан дарцаг, шөнийн цагаар улаан гэрлээр түүчээ зүтгүүрийн машинчийн зүг харуулж өгнө.

5.6. Зорчигчийн галт тэрэг хөдлөх үед вагоны үйлчлэгч нар зорчигчийг бүрэн буулган, суулгаж, аюулгүй байдлыг хангасны дараа эхний болон сүүлийн вагоны үйлчлэгч нар өдрийн цагаар хуйлсан шар дарцаг, шөнийн цагаар цагаан гэрлийг зорчигчийн тавцангийн зүг түүний төгсгөлийг хүртэл харуулна. Энэ нь жижүүрт галт тэргийг хэвийн аялж байгааг илтгэнэ.

5.7. Хэрэв замын тахир хэсэгт зорчигчийн галт тэрэгний сүүлчийн вагоны үйлчлэгчийн тахирын дотор талаас өгсөн дохиог бүх үйлчлэгч нар дамжуулан зүтгүүрийн бригадад өгнө.

5.8. Замын хэсэг болон зөвшөөрөгдсөн газарт зорчигчийн галт тэрэг зогсмогц вагоны үйлчлэгч нар вагоныхоо хаалгыг онгойлгож зорчигчийг бүрэн буулган, суулгаж, аюулгүй байдлыг хангасны дараа өдрийн цагаар хуйлсан шар дарцаг, шөнийн цагаар цагаан гэрлийг зүтгүүрийн бригадад харуулна. Машинч уг дохиогоор хөдөлгөөнөө үргэлжлүүлнэ.

5.9. Үзэгдэх орчин хязгаарлагдсанаас дохионы үзэгдэлт муудсан үед сүүлчийн вагоны үйлчлэгчээс зүтгүүрийн бригадад өгсөн дохиог бусад вагоны үйлчлэгч нар харилцан дамжуулна.

5.10. Хоорондын замд замын, гүүрний, нуранги үүсэж болзошгүй газрын замын эргүүл, гармын жижүүр, харуул нь галт тэргийг угтаж өнгөрүүлэхдээ зам чөлөөтэйг илтгэн өдрийн цагаар хуйлсан шар дарцаг /Зураг 76/, шөнийн цагаар

цагаан гэрлээр /Зураг 77/ дохио өгнө. Хэрвээ тухайн газарт саад гарвал хурд бууруулах эсхүл зогсоох дохио өгнө.



Зураг 76



Зураг 77


ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ДОХИОНЫ ТЭМДЭГ БА ЗААГЧ

6.1. Галт тэргийг хүлээн авах болон явуулах замд чиглэлийн мэдээлэл өгөх зорилгоор замнал заагч /тоо, үсэг, чиглэл заасан/-ийг байрлуулж болно. Царигийн ялгаатай өртөөнд шаардлагатай тохиолдолд цариг шилжих мэдээлэл өгч болно.


6.1.1. Замнал заагчийг гэрлэн дохионы шон эсвэл бие даасан шонд байрлуулна.

6.1.2. явах чиглэл, цариг шилжих мэдээллийг цагаан өнгийн гэрэлтэй замнал заагчийг хэрэглэнэ. /Зураг 78/



Зураг 78


6.1.3. галт тэрэг явуулахыг зөвшөөрсөн замын дугаарыг заахдаа ногоон өнгийн гэрэлтэй бүлэгчилсэн замнал заагчийг хэрэглэнэ. /Зураг 79/



Зураг 79


6.2. Гар суман шилжүүлгийн заагч нь гэрэл ойлгогчтой байх ба цагаан дэвсгэр дээр хар өнгөтэй, сум хэлбэртэй байна.

6.2.1. суман шилжүүлгийг шулуун замд шилжүүлсэн үед заагч нь шулуун зам руу чиглэсэн байна. /Зураг 80/




Зураг 80

6.2.2. Суман шилжүүлгийг хажуугийн замд шилжүүлсэн үед заагч нь хажуугийн зам руу чиглэсэн байна. /Зураг 81/




Зураг 81

6.3. Мухар замын хаалтын заагч нь гэрэл ойлгогчтой байх ба тулгуурын баруун талд тухайн зам руу харуулж байрлуулна. /Зураг 82/




Зураг 82

6.4. Хязгаарын шонг суман шилжүүлэг ба огтлолцлын чиглэлд уг шонгоос цааш хөдлөх бүрэлдэхүүн зогсоож болохгүй газрыг заана. /Зураг 83, 84/ Төмөр замын гол /Зураг 83/ болон хүлээн авах, явуулах замын /Зураг 84/ хязгаарын шонг хар цагаанаар алаглуулан будсан байна.



Зураг 83




Зураг 84

6.5. “Өртөөний зааг” тэмдэг нь өртөөний хязгаарыг илэрхийлнэ. /Зураг 85/




Зураг 85

6.6. “Осолтой газрын эхлэл” /Зураг 86/, “Осолтой газрын төгсгөл” /Зураг 87/ байнгын тэмдэг нь галт тэрэг бууруулсан хурдтай явахыг шаардах замын хэсгийн хязгаарыг заана.



Зураг 86




Зураг 87

6.6.1. “Осолтой газрын төгсгөл” дохионы тэмдгийг “Осолтой газрын эхлэл” гэсэн тэмдгийн ар тал дээр байрлуулна.

6.7. Анхааруулах дохионы тэмдэг нь дараах заалт өгнө.

6.7.1. “Ш” тэмдэг нь гүүр, гарам, хонгил, тахир тойруу ба үзэгдэх орчин хязгаарлагдсан хэсэгт галт тэрэг дуут дохио өгөх газрыг заана. /Зураг 88/



Зураг 88


6.7.2. **Зүтгүүрийг зогсоо** тэмдгийг байрлуулах газрыг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч тогтооно. /Зураг 89/



Зураг 89

6.7.3. тоормос шалгах газрын заагч **“Т”** тэмдэг нь хоорондын замд галт тэрэгний тоормосны найдвартай ажиллагааг шалгах газрыг заана.

6.7.3.1. **“Т1”**–Галт тэрэгний тоормосыг бариулж, тоормосны найдвартай ажиллагааг шалгаж эхлэх газрыг заана. /Зураг 90/




6.7.3.2. “Т2”–Галт тэрэгний хурдыг **10 км/цаг** болон түүнээс дээш хэмжээгээр бууруулсан байх үеийн тоормосны замыг заана. /Зураг 91/

6.7.3.3. “Т3”–Галт тэрэгний хурдыг “Т2” тэмдэг хүртэл **10 км/цагаар** бууруулж чадаагүй боловч “Т3” тэмдэг хүртэл **10 км/цаг** ба түүнээс дээш хэмжээгээр бууруулж байвал уг галт тэргийг **25 км/цагаас** ихгүй хурдтай дараагийн өртөө хүртэл явахыг зөвшөөрнө. /Зураг 92/

6.7.3.4. Хэрэв “Т3” тэмдгийн дэргэд ирэх үед галт тэрэгний хурд **10 км/цагаас** багагүй хэмжээгээр буураагүй тохиолдолд яаралтай зогсож шалтгааныг тодруулахыг машинчаас шаардана.

6.7.4. “Түлхэлт эхлэх” /Зураг 93/, “Түлхэлт дуусах” /Зураг 94/ тэмдгийг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн шийдвэрээр тогтоосон газарт байрлуулна




Зураг 93



Зураг 94


6.8. Цас цэвэрлэгч механизм ажиллах хэсэгт дохионы дараах түр тэмдэг хэрэглэнэ.

6.8.1. саадтай газрын өмнө “Хусуураа өргөн далавчаа эвх” гэсэн тэмдэг тавина. /Зураг 95/




Зураг 95

6.8.2. саадтай газар өнгөрсний дараа “Хусуураа буулгаж, далавчаа дэлгэ” гэсэн тэмдэг тавина. /Зураг 96/




Зураг 96

6.8.3. цас цэвэрлэгч механизм ажилладаг замын хэсэгт “Хусуураа өргөн далавчаа эвх” тэмдгийн өмнө “Далавчаа эвхэж, хусуураа өргөхөд бэлтгэ” дохионы түр тэмдгийг тавина. /Зураг 97/




Зураг 97

6.8.4. цас цэвэрлэгч механизм ажилладаг замын хэсэгт дохионы түр тэмдгийг “Зураг 98”-т заасны дагуу байрлуулна.



Зураг 98

6.9. Ойролцоо хоёр саадын хооронд цас цэвэрлэгч механизм ажиллаж болохгүй тохиолдолд нэг ишинд хоёр тэмдгийг дараалан байрлуулна. /Зураг 99/




Зураг 99


ДОЛООДУГААР БҮЛЭГ
СЭЛГЭЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЕД ХЭРЭГЛЭХ ДОХИО

7.1. Сэлгээний гэрлэн дохио дараах дохиог өгнө.

7.1.1. **Нэг цагаан гэрэл** – Сэлгээний хөдөлгөөн хийхийг зөвшөөрнө. (Зураг 100, 101)



Зураг 100




Зураг 101

7.1.2. **Нэг хөх гэрэл** – Сэлгээний хөдөлгөөн хийхийг хориглоно. (Зураг 102, 103)




Зураг 102




Зураг 103

7.1.2. гаргах ба замналын гэрлэн дохионы улаан гэрэл унтарсан үед тэдгээрийн цагаан гэрлээр сэлгээний хөдөлгөөн хийхийг зөвшөөрнө.

7.1.3. өртөөний тодорхой бэлчирт сэлгээний хөдөлгөөнийг зөвшөөрсөн сэлгээний бүлэг гэрлэн дохио нь нэг буюу хоёр талдаа дохиолно. Галт тэрэг хүлээн авч, явуулдаггүй замууд, мухар замууд түүнчлэн сэлгээний хөдөлгөөн хийгддэг нийт замуудын сэлгээний гэрлэн дохионд улаан гэрлийг заавал байрлуулна. /Зураг 104, 105/




Зураг 104



Зураг 105


7.2. Ялгах довын гэрлэн дохио дараах дохиог өгнө.

7.2.1. **ногоон гэрэл** – Вагоныг тогтоосон хурдтай ялган тараахыг зөвшөөрнө. /Зураг 106/




Зураг 106

7.2.2. **шар гэрэл** – Вагоныг бууруулсан хурдтай ялган тараахыг зөвшөөрнө. / Зураг 107/




Зураг 107

7.2.3. **улаан гэрэл** – “Зогс! Ялган тараах үйлдлийг хориглоно.” / Зураг 108/



Зураг 108

7.2.4. гэрлэн дохионы улаан гэрэлтэй хамт ассан цагаан өнгөтэй гэрлэн заагч дээрх “У” үсэг нь вагоныг ухраан суулгах аргаар сэлгээ хийхийг шаардана. / Зураг 109/



Зураг 109

7.2.5. хэрэв ялгах довын гэрлэн дохионы үзэгдэлт хангалтгүй байвал заалтыг машинчид мэдэгдэхийн тулд давтах гэрлэн дохиог байрлуулна. Давтах гэрлэн дохио нь ялгах довын үндсэн гэрлэн дохионы гэрэлтэй адил гэрлээр дохиолно. Хүлээн авах паркийн замын дунд хэсэгт байрлуулсан давтах гэрлэн дохионд улаан гэрлийн оронд хөх гэрлийг хэрэглэж болно.

7.2.6. Хүлээн авах паркийн замаас ялгах довын гэрлэн дохио хүртэл, мөн хөдлөх бүрэлдэхүүнийг явуулахыг зөвшөөрөхийн тулд сэлгээний гэрлэн дохиог хэрэглэж болно.

7.2.8. Сэлгээний гэрлэн дохиогүй өртөөнд гаргах гэрлэн дохионы хориглосон заалтаар сэлгээ хийх зөвшөөрлийг өртөөний жижүүрийн бүртгэлт тушаалаар сэлгээний удирдагч гүйцэтгэнэ.

7.3. Сэлгээний хөдөлгөөний үед гар ба дуут дохиогоор дараах дохиог өгнө.

7.3.1. “зүтгүүрийг урагшаа хөдөлгө” дохиог өдөр дэлгэсэн шар дарцаг /Зураг 110/, шөнө цагаан гэрлээр толгой дээгүүрээ хоёр тийш нь хөдөлгөх /Зураг 111/ бөгөөд шүглээр нэг урт дуугаргаж өгнө.



Зураг 110




Зураг 111

7.3.2. “Зүтгүүр ухар” дохиог өдөр дэлгэсэн шар дарцаг /Зураг 112/, шөнө цагаан гэрлийг /Зураг 113/ хөлийн өмнүүр хоёр тийш нь хөдөлгөх бөгөөд шүглээр хоёр урт дуугаргаж өгнө.




Зураг 112




Зураг 113

7.3.3. “Хурдаа бууруул” дохиог өдөр дэлгэсэн шар дарцаг /Зураг 114/, шөнө цагаан гэрлийг /Зураг 115/ хажуудаа дээш доош нь алгуур хөдөлгөх бөгөөд шүглээр хоёр богино дуугаргаж өгнө.




Зураг 114




Зураг 115

7.3.4. “Зогс!” дохиог өдөр дэлгэсэн улаан буюу шар дарцаг /Зураг 116/, шөнө ямар нэгэн гэрлээр /Зураг 117/ даллан эргүүлэх бөгөөд шүглээр гурван богино дуугаргаж өгнө.



Зураг 116



Зураг 117


7.3.5. Сэлгээний хөдөлгөөний удирдлагын шийдвэрийг радио холбоогоор дамжуулна. Радио холбоо нь дохионы үүрэг гүйцэтгэхгүй.

7.3.6. Сэлгээний хөдөлгөөний үед өгч байгаа дохиог радио холбоо, зүтгүүрийн шүглээр давтаж уг дохиог гүйцэтгэхээр хүлээн авсан тухайгаа батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ ГАЛТ ТЭРЭГНИЙ ДОХИО


8.1. Галт тэрэгний зүтгүүр, вагонд хэрэглэх дохио: **

8.1.1. Өдрийн цагт явж байгаа галт тэрэгний зүтгүүрт дохио тавихгүй.
/Зураг 118/



Зураг 118


8.1.2. Хоорондын замд явж байгаа галт тэрэгний зүтгүүр нь шөнийн цагт бамбайн ялууны дээд талд хоёр цагаан гэрэлтэй байна. /Зураг 119/




Зураг 119

** ТАЙЛБАР: Дохиог баруун, зүүн талд байрлуулах талаарх бүх заалтыг хөдөлгөөний чиглэлийн дагуу харуулсан болно.

8.1.3. Галт тэрэгний сүүлд яваа зүтгүүрийн бамбайн ялууны баруун талд өдрийн цагт улаан зээрэнхий буюу улаан дарцаг/Зураг 120/, шөнийн цагт улаан гэрэлтэй байна. /Зураг 121/




Зураг 120




Зураг 121

8.1.4. Ачааны галт тэрэг вагонтой талаараа урагш явах үед галт тэрэгний эхний вагоныг өдрийн цагт автоугсрааны зүүн талд нэг улаан зээрэнхий тавьж эхний вагоны гишгүүр /дамжих тавцан/ дээр ажилтан зүүн гар талдаа дохио өгч явна. /Зураг 122/ Шөнийн цагт эхний вагоны гишгүүр /дамжих тавцан/ дээр ажилтан зүүн гар талдаа цагаан өнгийн гэрлээр дохио өгч явна. /Зураг 123/




Зураг 122




Зураг 123

8.1.5. Ачаа, ачаа-зорчигчийн галт тэрэгний сүүлийг өдрийн ба шөнийн цагт сүүлийн вагоны автоугсрааны баруун талд нэг маягийн улаан зээрэнхий өлгөнө. /Зураг 124/




Зураг 124

8.1.6. Зорчигчийн галт тэрэгний сүүлийн вагоныг өдөр, шөнийн аль ч цагт гурван улаан гэрэлтэй байна. /Зураг 125/



Зураг 125

8.1.7. Дохионы байнгын гэрэлгүй вагоныг зорчигчийн галт тэрэгний сүүлд холбох бол өдрийн цагаар сүүлийн вагоны автоугсрааны баруун талд нэг маягийн улаан зээрэнхий /Зураг 124/, шөнийн цагаар сүүлийн вагоны автоугсрааны баруун талд улаан гэрэлтэй байна. /Зураг 126/




Зураг 126

8.1.8. Түлхэгч зүтгүүр ба өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүнд ганцаараа яваа зүтгүүрийн нэгэн адил дохиог хэрэглэнэ.


8.2. Хоорондын замд галт тэргийг мөрдөж явуулах үед дараах дохиог хэрэглэнэ:

8.2.1. эхний галт тэрэг буюу ганцаараа яваа зүтгүүрт бамбайн ялууны баруун талд дэлгэсэн шар дарцаг нэмж өлгөнө. /Зураг 127/




Зураг 127

8.2.2. галт тэргийг хоорондын замаас хэсэгчлэн татаж авахдаа хамгийн сүүлийнхээс бусад хэсэг бүрийн сүүлийн вагоны автоугсрааны баруун талд өдрийн цагт дэлгэсэн шар дарцаг /Зураг 128/, шөнийн цагт шар гэрэлтэй байна. /Зураг 129/



Зураг 128




Зураг 129


8.2.3. Хамгийн сүүлийн татан авч байгаа хэсгийн сүүлийн вагоныг ердийн ачааны галт тэрэгний адил дохиогоор хангана.

8.3. Цас цэвэрлэгч механизм явах үед дараах дохиог хэрэглэнэ:

8.3.1. цас цэвэрлэгч механизм толгойд нь яваа бол түүний хажуугийн хоёр дэгээнд өдрийн цагт дэлгэсэн хоёр шар дарцаг /Зураг 130/, шөнийн цагт цас цэвэрлэгч механизмын хажуугийн хоёр шар гэрэлтэй байх бөгөөд зүтгүүр тийш хандсан тал нь хяналтын хоёр цагаан гэрэлтэй байна. /Зураг 131/




Зураг 130




Зураг 131

8.3.2. зүтгүүр толгойд нь яваа бол өдрийн цагт бамбайн ялууны гэрлийн дэргэд дэлгэсэн хоёр шар дарцаг /Зураг 132/, шөнийн цагт бамбайн ялуу нь хоёр шар гэрэлтэй байна. /Зураг 133/



Зураг 132



Зураг 133

8.3.3. цас цэвэрлэгч механизмын сүүлийг ганцаараа яваа зүтгүүрийн нэг адил дохиогоор хангана.

8.4. Галт тэрэгний бүрэлдэхүүнд очих, буцах, сэлгээний хөдөлгөөн хийж зүтгүүрийн ард, урд шөнийн цагт бамбайн ялууны машинчийн талд нэг цагаан гэрэлтэй байна.

8.5. Замаас авагддаг хөдөлгөөнт нэгж, тэргэнцэр, мөн замаас авч болдог бусад төхөөрөмжийг хоорондын замд ажиллуулахдаа дор дурдсан дохиогоор хамгаалсан байна:

8.5.1. өдрийн цагт хоёр тал нь улаан өнгийн тэгш өнцөгт дөрвөлжин самбар эсвэл урт иштэй дэлгэсэн улаан дарцаг, шөнийн цагт урт ишинд байрлуулсан хоёр талдаа улаан гэрэл /ар, өвөр талдаа харагдах/ байна.

8.5.2. хоорондын замд ажиллаж байгаа тэргэнцрийг дээрх дохионоос гадна хоёр талд нь 800 метр зайтай газарт гар ба зөөврийн улаан дохиогоор дохиочин хааж хамгаалах бөгөөд тэргэнцэртэй нэгэн зэрэг хөдлөхөөр зохицуулна.

8.5.3. тэргэнцэр өртөөнд ажиллаж байхдаа өдрийн цагт хоёр тал нь улаан самбар эсвэл урт иштэй улаан дарцаг, шөнийн цагт хоёр тал нь урт иштэй улаан гэрэлтэй байна.

8.5.4. өртөөний зам ба суман шилжүүлэг дээр ажиллаж байгаа тэргэнцрийг хоёр талд нь 50 метр зайтай газарт гар ба зөөврийн улаан дохиогоор хааж бөгөөд тэргэнцрийг хөдлөхтэй нэгэн зэрэг дохиог өөрчлөн байрлуулна.



8.5.5. тэргэнцэр болон замаас авагддаг бусад төхөөрөмжийг хоёр талаас нь хааж явах төмөр замын ажилтан, түүнчлэн эдгээр төхөөрөмжийн хөдөлгөөнийг удирдаж яваа ажилтан зөөврийн самбар, гар дарцаг, дохионы гэрлээс гадна галт тэрэг ойртож байгаа тухай мэдэгдэх, шаардлагатай тохиолдолд галт тэргийг зогсооход зориулсан бялт ба бүрээстэй байна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ









ДУУТ ДОХИО

9.1. Галт тэрэгний хөдөлгөөнд хэрэглэгдэх дуут дохиог шүгэл, бүрээ, зүтгүүрийн ба өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний шүгэл зэргээр өгнө.

Хүснэгт 2. Галт тэрэгт өгөх дуут дохио^{††}

д/д	Дохио	Дохионы шаардлага	Дохиог өгөх субъект
1.	Гурван богино 	“Зогс”	Зүтгүүр ба галт тэрэгний бригад, өртөөний болон галт тэрэгний хөдөлгөөнд оролцдог бусад ажилтан өгнө
2.	Нэг урт 	“Галт тэргийг явуул”	Өртөөний замд галт тэргэнд өртөөний жижүүр буюу техник захирамжийн актад заасан ажилтан, аж ахуйн галт тэргэнд түүний ажил удирдагч, сэлгээний үед найруулагчийн бригад өгнө. Түүчээ зүтгүүрийн машинч зүтгүүрийн шүглээр хариу өгнө. Хос зүтгүүртэй бол хоёр дахь зүтгүүрийн машинч дохиог давтана.

^{††} Тайлбар: Түлхэгч зүтгүүртэй бол түүнээс өгсөн бүх дохиог хоёрдугаар зүтгүүрийн машинч давтана.

3.	Гурван урт 	Галт тэрэгний бригадад “Тоормосол” гэж шаардана.	Галт тэрэг авч яваа түүчээ зүтгүүрийн машинч өгнө. Хоёр зүтгүүртэй бол хоёр дахь зүтгүүрийн машинч давтана.
4.	Хоёр урт 	Галт тэрэгний бригадад “Тоормосоо сулла” гэж шаардана.	Галт тэрэг авч яваа түүчээ зүтгүүрийн машинч өгнө. Хос зүтгүүртэй бол хоёр дахь зүтгүүрийн машинч давтана.
5.	Гурван урт нэг богино 	Өртөөнд галт тэрэг бүрэн бус бүрэлдэхүүнтэй ирсэн.	Зүтгүүрийн машинч өгнө.
6.	Гурван урт хоёр богино 	Машинчаас туслах машинч, механик-бригадын дарга, ажил удирдагчийг зүтгүүрт дуудах	Хоорондын замд зогссон буюу зам засварын ажил хийж байх үед зүтгүүрийн машинч өгнө.
Хос зүтгүүртэй яваа үед			
7.	Нэг богино 	Хоёр дахь зүтгүүрийн машинчид хурдаа бууруулахыг шаардана.	Түүчээ зүтгүүрийн машинч өгнө.
8.	Хоёр богино 	Хоёр дахь зүтгүүрийн машинчид хурд нэмэхийг шаардана.	Түүчээ зүтгүүрийн машинч өгнө. Дохиог хоёр дахь зүтгүүрийн машинч давтана.
9.	Хоёр богино 	Түлхэгч зүтгүүртэй явахад “Түлхэлт эхлэх”-ийг шаардана.	Галт тэрэгний зүтгүүрийн машинч өгч түлхэгч зүтгүүрийн машинч дохиог давтана.
10.	Нэг богино, нэг урт, нэг богино 	“Түлхэлт зогсоо” гэвч галт тэрэгнээс битгий хоцор гэж шаардана.	Галт тэрэгний түүчээ зүтгүүрийн машинч өгч түлхэгч зүтгүүрийн машинч дохиог давтана.

11.	Дөрвөн урт ■■■■	Түлхэлт зогсоож, буцахыг шаардана.	Галт тэрэгний зүтгүүрийн машинч өгч түлхэгч зүтгүүрийн машинч дохиог давтана.
-----	--------------------	------------------------------------	---

Хүснэгт 3. Сэлгээний хөдөлгөөний үед хэрэглэх дуут дохио

12.	Нэг урт ■	Сэлгээ урагшаа яв.	Найруулагчийн бригад өгч машинч давтана.
13.	Хоёр урт ■■ ■■	Сэлгээний бүрэлдэхүүн ухар.	Найруулагчийн бригад өгч машинч давтана.
14.	Хоёр богино ● ●	Сэлгээний бүрэлдэхүүн хурдаа бууруул.	Найруулагчийн бригад өгч машинч давтана.
15.	Гурван богино ● ● ●	Зогс	Найруулагчийн бригад өгч машинч давтана

9.2. Мэдэгдэх дохиог өртөө, замын пост, зорчигч буух, суух газар, шүгэл дуугаргахыг шаардах дохионы “Ш” тэмдэг, хурд бууруулах зөөврийн ба гар дохионууд, сэтэрхий, тойруу зам, хонгил, гарам, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүн, замаас авагддаг тэргэнцэр болон зам дээр байгаа хүмүүст галт тэрэг ойртож ирж байгааг зүтгүүр, өөрөө явагч тусгай бүрэлдэхүүний шүглийг нэг урт дуугаргаж мэдэгдэнэ.

9.3. Ажил хийж байгаа газарт галт тэрэг ойртоход зөөврийн дохио байгаа эсэхийг харгалзахгүйгээр анхаарамж бичигт дурдсан километрийн өмнөх километрээс эхлэн шүглээ нэг урт дуугаргаж мэдэгдэнэ.

9.4. Цаг агаарын хүндрэлтэй манан будан, цасан ба шороон шуурга зэрэг үзэгдэх орчин хязгаарлагдсан үед дохиог байнга давтан өгч байна.

9.5. Хоорондын замд зам, гүүр, хонгил, нурж болох газрын эргүүл, гармын жижүүр, замын ажил удирдаж байгаа ажилтан, замаас авагддаг тэргэнцэр авч яваа дохиочид, ажилтан галт тэрэг ойртож яваа дохиог бүрээгээр өгнө.

9.6. Сондгой чиглэлийн галт тэрэг ойртож явааг бүрээгээр нэг урт, тэгш чиглэлийн галт тэрэг ойртож явааг хоёр урт дуугаргаж мэдэгдэнэ.

9.7. Өртөөний зам дээр байгаа зорчигчийн, ачаа-зорчигчийн, хүн тээсэн галт тэргэнд суух ба тэдгээрийг явуулах тухай зорчигчдод чанга яригчийн холбоогоор зарлан мэдэгдэнэ.

9.8. Мэдэгдэх дохиог ойлгомогц зам дээр ажиллаж байгаа бүх ажилтнууд замын хажууд гарч галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаад хяналт тавьж өнгөрүүлнэ.

9.9. Урих гэрлэн дохиогоор болон оруулах гэрлэн дохионы хориглосон заалтаар өртөө рүү орох үед сэрэмжлэх дохиог зүтгүүрийн шүглээр нэг богино нэг уртаар давталтайгаар өгнө.

АРАВДУГААР БҮЛЭГ

ТҮГШҮҮРИЙН ДОХИО БА ТУСГАЙ ТЭМДЭГ

10.1. Түгшүүрийн дохиог зүтгүүр, өөрөө явагч тусгай бүрэлдэхүүний шүгэл, бүрээ, тусгай зориулалтын дуут дохио, эдгээр байхгүй үед өлгөсөн төмөр эдлэлээр дуу гаргаж өгнө.

10.2. Түгшүүрийн дохиог хоорондын замд зүтгүүр, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний шүглээр өгнө.

10.3. Түгшүүрийн дохиог өртөө, зөрлөг, аж ахуйн нэгж, байгууллага дээр өлгөсөн төмөр эдлэлийг бүдүүвчийн дагуу цохиж 1-ээс 2 минутын турш үе үе давтаж өгнө. Химийн аюулын дохиог өртөөн дээр төмөр замын ажилтан өгөх бөгөөд хоорондын замд зүтгүүр, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний жолооч өгнө.

10.3.1. нийтийн түгшүүрийн дохиог нэг урт гурван богино дуу гаргаж дор дурдсан нөхцөлүүдэд өгнө.



10.3.1.1. галт тэрэгний хөдөлгөөнд аюул учруулж болох гэмтэл зам дээр илэрсэн үед;

10.3.1.2. галт тэргэнд сүйрэл тохиолдох, цасан болон элсэн хунгарт саатан зогсох зэрэг тусламж шаардах үед.

10.3.2. галын түгшүүрийн дохиог нэг урт хоёр богино дуу гаргаж өгнө.



10.3.3. шаардлагатай үед нийтийн ба галын түгшүүрийн дохиог төмөр замын ямар ч ажилтан өгнө.

10.3.4. агаарын түгшүүрийн “АТ” дохиог 3 минутын турш тасралтгүй олон богино дуугаргаж зүтгүүр, өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний шүглээр яаралтай давтана.



10.3.5. Цацраг идэвхт болон химийн аюулын “ХА” дохиог нэг урт, нэг богино дуу гаргаж өгнө.




10.3.6. Агаарын түгшүүр болон химийн аюул өнгөрсөн тухай төмөр замын ажилтан зорчигч иргэдэд дараах байдлаар мэдэгдэнэ.

10.3.6.1. өртөөн дээр бол өртөөний дарга буюу түүний томилсон ажилтны шийдвэрээр радио нэвтрүүлгийн сүлжээ, бусад холбооны хэрэгслээр болон хүн явуулж мэдэгдэнэ.

10.3.6.2. хоорондын замд яваа зорчигчийн галт тэргэнд галт тэрэгний даргын шийдвэрээр галт тэрэгний зохих албан тушаалтнаар болон галт тэрэгний радио нэвтрүүлгийн сүлжээгээр, цэргийн галт тэрэг бол цувааны даргын шийдвэрээр цувааны холбооны хэрэгслээр дамжуулан тус тус мэдэгдэнэ.


10.4. Хортой хэсгээр галт тэрэг явж өнгөрнө гэдгийг зүтгүүрийн ба галт тэрэгний бригадад мэдэгдэнэ.

10.4.1. хордсон хэсэгт хүмүүсийг баг, хамгаалах тусгай хувцас зэрэг тусгай хамгаалалтгүйгээр оруулахгүйн тулд уг газрыг “Хортой”, “Энд хортой” гэдэг тусгай тэмдгээр хаана. /Зураг 134/



Зураг 134

10.4.2. “Хортой”, “Энд хортой” гэсэн тусгай тэмдгийг “Зураг 135”-д заасны дагуу байрлуулна.



Зураг 135

10.4.3. хоорондын зам буюу өртөөн дээр хордсон газрын хязгаараас 50 метрийн зайд “Энд хортой” гэсэн тэмдгийг байрлуулна.

10.4.4. галт тэрэгний хөдөлгөөний чиглэлийн дагуу “Хортой” гэсэн нэгдүгээр тэмдгийн өмнө машинч нь химийн аюулын дохио өгөөд хордсон газрыг тогтоосон хурдаар явж өнгөрнө.

10.4.5. “Хортой”, “Энд хортой” гэсэн тэмдэг нь шөнийн цагт гэрэлтүүлэгтэй, эсхүл гэрэл ойлгогчтой байна.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН ТЕХНОЛОГИЙН ХОЛБОО

11.1. Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь дараах төрлийн шуурхай технологийн холбоотой байна. Үүнд:

- 11.1.1. Хөдөлгөөний диспетчерийн холбоо /өртөө, зөрлөгийн жижүүрүүд/;
- 11.1.2. Диспетчерийн холбоо /зам, эрчим хүч, дохиолол холбоо гэх мэт
- 11.1.3. галт тэрэгний радио холбоо;
- 11.1.4. гармын жижүүрийн холбоо;
- 11.1.5. өртөө хоорондын холбоо;
- 11.1.6. сэлгээний радио холбоо;
- 11.1.7. зөвлөгөөний холбоо;
- 11.1.8. Чанга яригчийн холбоо.

11.2. Төмөр замын тээвэрлэгч нь дараах төрлийн шуурхай технологийн холбоотой байна. Үүнд:

- 11.2.1. Хөдөлгөөний диспетчерийн холбоо /өртөө, зөрлөгийн жижүүрүүд/;
- 11.2.2. Диспетчерийн холбоо /зам, эрчим хүч, дохиолол холбоо гэх мэт
- 11.2.3. зөвлөгөөний холбоо;
- 11.2.4. галт тэрэгний радио холбоо;
- 11.2.5. хамгаалах нэгжийн холбоо;/Зүтгүүр, вагон, ачаа, хамгаалалт гэх мэт/

11.3. Технологийн зориулалттай холбоог нэгтгэсэн байж болно.

11.4. Технологийн холбоонд тавих үндсэн шаардлага:

- 11.4.1. шуурхай технологийн холбоо нь бусад төрлийн холбооноос хамааралгүй, бие даасан сүлжээ байх;
- 11.4.2. олон улсын байгууллагаар баталгаажуулсан радио холбоо ашиглах;
- 11.4.3. радио долгионы тархалт суурь бүтцийн хязгаарт тасалдал үүсгэхгүй байхаар ажиллах;
- 11.4.4. галт тэрэгний диспетчерийн холбоо нь 2 талын буюу нэвтрүүлэх, хүлээн авах сувагтай байх;
- 11.4.5. өртөө хоорондын холбоо нь холбогдож байгаа өртөө, зөрлөгийн жижүүрүүд шууд буюу дугаар сонгохгүй дуудлага хийх боломжтой байх;
- 11.4.6. бүх төрлийн диспетчерийн холбоо нь тус тусдаа сувагтай, хэрэглэгчийг ганцаарчилсан, бүлэглэж, нийтээр дуудах боломжтой, давуу

эрхтэй, хэрэглэгч холбогдох нь нээлттэй, яриагаар дуудах боломжтой байх;

11.4.7. технологийн холбоо нь яриа бичлэгийг хадгалах төхөөрөмжтэй байна;

11.4.8. радио холбоогоор төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд суваг солих байдлаар холбогдох боломжтой байна.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

12.1. Энэхүү журмын хэрэгжилтэд төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зам, тээврийн хяналт хариуцсан нэгж, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нар тус тусын бүрэн эрхийн хэмжээнд хяналт тавина.

12.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---

Гарчиг

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	1
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	1
ХОЁРДУГААР БҮЛЭГ.....	1
ДОХИОНЫ АНГИЛАЛ, ЗОРИУЛАЛТ	1
ГУРАВДУГААР БҮЛЭГ	2
ГЭРЛЭН ДОХИО	2
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.....	17
ЗӨӨВРИЙН ДОХИО	17
ТАВДУГААР БҮЛЭГ.....	30
ГАР ДОХИО	30
ЗУРГААДУГААР БҮЛЭГ	37
ДОХИОНЫ ТЭМДЭГ БА ЗААГЧ	37
ДОЛООДУГААР БҮЛЭГ	46
СЭЛГЭЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЕД ХЭРЭГЛЭХ ДОХИО	46
НАЙМДУГААР БҮЛЭГ.....	52
ГАЛТ ТЭРЭГНИЙ ДОХИО	52
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ.....	60
ДУУТ ДОХИО.....	60
АРАВДУГААР БҮЛЭГ	63
ТҮГШҮҮРИЙН ДОХИО БА ТУСГАЙ ТЭМДЭГ	63
АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	65
ТӨМӨР ЗАМЫН ТЕХНОЛОГИЙН ХОЛБОО	65
АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ	66
ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА.....	66